

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/093/НА-СТА-ТШЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХөрөнгө	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119. Утас/Факс (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 388
танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
А.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Засаг даргын тамгын гарын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Орон нутгийн гүйцэтгэх удирдлага”, “Хот байгуулалт, тохижилт”, “Ахмад настны хөгжил хамгаалал” хөтөлбөр, 6 арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс 5,277,475.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 96.4 хувь буюу 5,087,266.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 190,209.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 109,790.2 мянган төгрөг төвлөрснөөс 99,897.4 мянган төгрөгийг зарцуулж, 9,892.8 мянган төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын тамгын газарт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 409,313.9 мянган төгрөгийн “Иргэдэд үйлчлэх хурдан төвийн нарны толь суулгах, цахилгаан машин цэнэглэгч суурилуулах ажил”, 587,331.3 мянган төгрөгийн “Тамгын газрын байр, дээвэр, инженерийн шугам сүлжээ, гражийн засварын ажил” хийгдсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 347 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 91.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	481,401,752.00	255,850,288.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,970,550.00	2,234,827.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,970,550.00	2,234,827.00
3121	Төгрөг	4,970,550.00	2,234,827.00
31211	Төрийн сангийн харилцах	4,954,550.00	2,234,827.00
31213	Арилжааны банк дахь харилцах	16,000.00	
33	АВЛАГА	2,633,653.40	15,494,155.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		816,014.25
335	Бусад авлага	2,633,653.40	14,678,141.50
3351	Байгууллагаас авах авлага	133,653.40	12,178,141.50
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,500,000.00	2,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	473,797,548.60	238,121,306.00
354	Хангамжийн материал	424,852,548.60	191,141,306.00
35410	Бичиг хэргийн материал	1,015,000.00	4,248,400.00
35420	Аж ахуйн материал	389,901,058.60	164,722,906.00
35430	Сэлбэг хэрэгсэл	15,936,490.00	
35440	Түлш, шатах тослох материал	18,000,000.00	22,170,000.00
35600	Мал амьтад	48,945,000.00	46,980,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,268,521,566.27	5,242,347,078.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,268,521,566.27	5,242,347,078.26
392	Биет хөрөнгө	3,968,469,899.63	4,881,540,245.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,441,659,867.00	3,529,441,650.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	-486,758,990.71	-524,116,485.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	634,395,217.84	845,517,777.84
39204	Хуримтлагдсан элэгдэл	-385,832,913.89	-388,952,777.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	953,498,598.12	1,200,979,262.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-658,252,832.86	-328,771,532.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	364,092,065.57	223,384,637.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-301,697,247.64	-73,413,836.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	606,106,383.00	576,972,050.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-198,740,246.80	-179,500,500.32
393	Биет бус хөрөнгө	300,051,666.64	360,806,833.26
39301	Програм хангамж	47,900,000.00	24,610,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-44,673,333.36	-753,166.74
39303	Бусад биет бус хөрөнгө	296,825,000.00	336,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,749,923,318.27	5,498,197,367.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	27,376,204.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	27,376,204.00
413	Өглөг	0.00	27,376,204.00
4136	Бусад өглөг	0.00	27,376,204.00
41361	Байгууллагад төлөх өглөг		27,376,204.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,749,923,318.27	5,470,821,163.01
51	Засгийн газрын хувь оролцоо	4,749,923,318.27	5,470,821,163.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,485,687,328.00	1,485,687,328.00
51101	Өмч: - төрийн	1,230,487,328.00	1,230,487,328.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	255,200,000.00	255,200,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,139,700,794.12	2,860,598,638.86
51210	Өмнөх үеийн үр дүн	2,139,700,794.12	2,139,684,794.12
51220	Тайлант үеийн үр дүн		720,913,844.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,124,535,196.15	1,124,535,196.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,749,923,318.27	5,498,197,367.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,188,642,547.60	7,273,556,657.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,151,258,919.60	1,888,354,807.25
120	Нийтлэг татварын бус орлого	1,151,258,919.60	1,888,354,807.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,151,258,919.60	1,888,354,807.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,767,169.00	52,592,917.25
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,107,491,750.60	1,835,761,890.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,037,383,628.00	5,385,201,850.02
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	343,867,328.00	107,725,950.02
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	93,239,783.00	52,730,126.02
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	250,627,545.00	54,995,824.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,693,494,300.00	5,277,475,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,693,494,300.00	5,277,475,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	22,000.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	22,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,443,975,541.86	6,047,860,135.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,443,975,541.86	6,047,860,135.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,928,103,351.16	5,658,246,539.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,396,180,025.57	2,863,570,848.55
210101	Үндсэн цалин	1,106,962,761.71	1,524,604,960.62
210102	Нэмэгдэл	941,217,132.47	909,035,387.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	106,388,231.73	253,330,000.00
210104	Урамшуулал	122,093,306.44	125,761,951.00
210105	Гэрээт ажлын хөлс	119,518,593.22	50,838,549.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	285,824,970.41	334,732,405.85
210201	Тэтгэврийн даатгал	193,345,243.84	225,337,115.53
210202	Тэтгэмжийн даатгал	22,984,163.96	27,277,256.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,465,862.90	13,466,731.75
210204	Ажилгүйдлийн даатгал	9,998,671.90	12,950,735.69
210205	Эрүүл мэндийн даатгал	47,031,027.81	55,700,566.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,204,784.32	197,846,821.74
210301	Гэрэл, цахилгаан	36,494,945.31	45,424,562.74
210302	Түлш, халаалт	153,885,061.00	145,389,783.00
210303	Цэвэр, бохир ус	6,124,778.01	7,032,476.00
210304	Байрны түрээс	5,700,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	194,602,716.10	759,669,730.00
210401	Бичиг хэрэг	34,485,500.00	72,628,640.00
210402	Тээвэр, шатахуун	90,336,578.00	155,803,897.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,145,491.10	29,251,806.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,095,147.00	24,828,422.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		476,616,965.00
2105	Нормативт зардал	1,608,500.00	5,672,129.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,608,500.00	5,672,129.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	162,099,366.20	162,678,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,341,600.00	
210604	Урсгал засвар	153,757,766.20	162,678,990.00
2107	Томилолт, зочны зардал	132,274,679.00	122,326,100.00
210701	Гадаад албан томилолт	2,849,280.00	
210702	Дотоод албан томилолт	123,187,600.00	113,701,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,237,799.00	8,624,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,090,188.50	209,209,444.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,455,000.00	175,179,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	26,737,926.00	21,976,590.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	691,520.50	1,260,977.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	231,500.00	154,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,263,760.00	10,471,760.00
210807	Газрын төлбөр	710,482.00	166,717.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,509,218,121.06	1,002,540,070.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,106,142,300.00	651,456,386.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	403,075,821.06	351,083,683.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	515,872,190.70	389,613,595.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	379,465,019.00	199,403,384.92
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		35,073,360.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,409,758.00	25,193,524.94
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	180,345,261.00	9,772,999.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	126,710,000.00	129,363,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	649.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		649.23
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	136,407,171.70	190,209,561.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	136,407,171.70	190,209,561.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	744,667,005.74	1,225,696,521.98
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	504,782,677.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		94,383,172.94
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		410,399,504.30
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-504,782,677.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	744,667,005.74	720,913,844.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,113,876,474.00	5,435,011,453.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,767,169.00	47,745,353.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,767,169.00	47,745,353.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,767,169.00	47,745,353.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,767,169.00	47,745,353.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,070,109,305.00	5,387,266,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	376,615,005.00	109,790,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	93,239,783.00	52,730,126.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	283,375,222.00	57,060,074.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,693,494,300.00	5,277,475,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,693,494,300.00	5,277,475,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,028,747,142.00	5,370,058,998.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,028,747,142.00	5,370,058,998.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,513,664,951.30	4,966,340,852.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,385,640,025.57	2,863,602,551.21
210101	Үндсэн цалин	1,156,898,237.16	1,426,825,697.52
210102	Нэмэгдэл	960,930,767.08	961,811,781.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	116,538,231.73	287,427,721.47
210104	Урамшуулал	112,093,306.44	136,698,801.19
210105	Гэрээт ажлын хөлс	39,179,483.16	50,838,549.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	285,936,623.81	334,885,764.27
210201	Тэтгэврийн даатгал	193,456,897.24	225,453,756.75
210202	Тэтгэмжийн даатгал	22,962,771.71	26,821,266.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,487,255.15	14,363,355.65
210204	Ажилгүйдлийн даатгал	9,998,671.90	12,408,641.12
210205	Эрүүл мэндийн даатгал	47,031,027.81	55,838,744.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,204,784.32	197,846,821.74
210301	Гэрэл, цахилгаан	34,261,505.31	45,424,562.74
210302	Түлш, халаалт	156,118,501.00	145,389,783.00
210303	Цэвэр, бохир ус	6,124,778.01	7,032,476.00
210304	Байрны түрээс	5,700,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	203,556,523.10	213,069,242.00
210401	Бичиг хэрэг	31,313,267.00	36,878,200.00
210402	Тээвэр, шатахуун	100,471,178.00	119,453,117.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,485,391.10	29,399,019.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,746,687.00	26,798,906.00
2105	Нормативт зардал	4,355,500.00	6,742,129.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,355,500.00	6,742,129.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	233,678,459.00	160,407,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	66,970,100.00	879,600.00
210602	Тавилга	6,488,960.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		5,737,000.00
210604	Урсгал засвар	160,219,399.00	153,791,250.00
2107	Томиллолт, зочны зардал	141,897,267.00	124,682,624.00
210701	Гадаад албан томиллолт	2,849,280.00	
210702	Дотоод албан томиллолт	124,089,600.00	113,701,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	14,958,387.00	10,981,024.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,889,040.50	220,529,531.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,555,000.00	186,129,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	26,619,975.00	21,976,590.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	809,471.50	1,113,764.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,413,760.00	10,969,060.00

210807	Газрын төлбөр	270,834.00	166,717.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,001,966,728.00	844,574,339.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,001,966,728.00	844,574,339.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	515,082,190.70	403,718,145.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	378,675,019.00	203,615,807.92
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		35,073,360.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,409,758.00	25,193,524.94
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	180,345,261.00	9,772,999.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	125,920,000.00	133,575,923.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	136,407,171.70	200,102,337.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	136,407,171.70	190,209,561.63
213404	Төвлөрүүлэх шилжүүлэг		9,892,776.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>85,129,332.00</u>	<u>64,952,455.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	80,270,332.00	67,688,178.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	80,270,332.00	67,688,178.00
2200	Дотоод эх үүсвэрээр	80,270,332.00	67,688,178.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	80,270,332.00	67,688,178.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-80,270,332.00</u>	<u>-67,688,178.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,859,000.00	-2,735,723.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	111,550.00	4,970,550.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,970,550.00	2,234,827.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	2,139,700,794.12		4,749,923,318.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	2,139,700,794.12	0.00	4,749,923,318.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	2,139,700,794.12	0.00	4,749,923,318.27
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	2,139,700,794.12	0.00	4,749,923,318.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			57,591,004.40		57,591,004.40
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	2,197,291,798.52	0.00	4,807,514,322.67
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-57,607,004.40			-57,607,004.40
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
Тайлант үеийн үр дүн			720,913,844.74		720,913,844.74
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,066,928,191.75	2,918,205,643.26	0.00	5,470,821,163.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,292,475,900.00	5,105,938,991.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,292,475,900.00	5,105,938,991.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,114,971,400.00	4,933,995,606.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,832,273,000.00	2,812,764,002.12
210101	Үндсэн цалин	1,429,797,900.00	1,426,825,697.52
210102	Нэмэгдэл	962,508,600.00	961,811,781.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	302,400,000.00	287,427,721.47
210104	Урамшуулал	137,566,500.00	136,698,801.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	337,159,200.00	329,714,015.59
210201	Тэтгэврийн даатгал	224,468,200.00	221,974,892.57
210202	Тэтгэмжийн даатгал	28,172,700.00	26,350,600.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,086,400.00	14,025,494.60
210204	Ажилгүйдлийн даатгал	14,086,400.00	12,293,039.82
210205	Эрүүл мэндийн даатгал	56,345,500.00	55,069,987.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,942,500.00	197,846,821.74
210301	Гэрэл, цахилгаан	48,424,500.00	45,424,562.74
210302	Түлш, халаалт	165,518,000.00	145,389,783.00
210303	Цэвэр, бохир ус	7,000,000.00	7,032,476.00
2104	Хангамж, бараа материалын зардал	208,510,100.00	185,037,876.00
210401	Бичиг хэрэг	20,000,000.00	18,538,090.00
210402	Тээвэр, шатахуун	120,000,000.00	109,761,861.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,533,200.00	29,399,019.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	540,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,076,900.00	26,798,906.00
2105	Нормативт зардал	6,750,000.00	6,742,129.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,750,000.00	6,742,129.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	267,283,500.00	228,096,028.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	44,250,000.00	43,643,390.00
210602	Тавилга	35,000,000.00	24,924,388.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,200,000.00	5,737,000.00
210604	Урсгал засвар	180,833,500.00	153,791,250.00
2107	Томилолт, зочны зардал	135,850,000.00	113,312,624.00
210702	Дотоод албан томилолт	120,850,000.00	102,331,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	15,000,000.00	10,981,024.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	261,020,900.00	220,529,531.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	221,553,900.00	186,129,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	22,000,000.00	21,976,590.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,800,000.00	1,113,764.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	720,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,247,000.00	10,989,060.00
210807	Газрын төлбөр	700,000.00	166,717.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	845,182,200.00	839,952,579.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	845,182,200.00	839,952,579.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	177,504,500.00	171,943,384.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	177,504,500.00	171,943,384.92
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,074,000.00	35,073,360.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,272,500.00	25,193,524.94
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,158,000.00	9,772,999.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	107,000,000.00	101,903,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,292,475,900.00	5,105,938,991.37
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,277,475,900.00	5,087,266,338.37
132001	Орон нутгийн төсвөөс	5,277,475,900.00	5,087,266,338.37
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	18,672,653.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	18,672,653.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,790,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109,790,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,897,423.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,838,549.09
210105	Гэрээт ажлын хөлс	50,838,549.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,171,748.68
210201	Тэтгэврийн даатгал	3,478,864.18
210202	Тэтгэмжийн даатгал	470,666.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	337,861.05
210204	Ажилгүйдлийн даатгал	115,601.30
210205	Эрүүл мэндийн даатгал	768,756.10
2104	Хангамж, бараа материалын зардал	28,031,366.00
210401	Бичиг хэрэг	18,340,110.00
210402	Тээвэр, шатахуун	9,691,256.00
2107	Томилолт, зочны зардал	11,370,000.00
210701	Гадаад албан томилолт	11,370,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,485,760.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,485,760.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,892,776.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,892,776.23
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,892,776.23
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,892,776.23
	II ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	109,790,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,790,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,730,126.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	57,060,074.00

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,134,759.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 13,860.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,120,899.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

1. Сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн аймгийн Засаг даргын орлогчоор ажиллаж байсан иргэнд 13,860.0 мянган төгрөгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсний тэтгэмж олгосон байна.

Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно." гэж заасныг зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

1. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 23,552.2 мянган төгрөгийг нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээнд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно." гэснийг зөрчсөн байна.

2. Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий зарлагын 40,894.9 мянган төгрөгийн 5 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,056,452.5 мянган төгрөгийн 70 худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

3. Аймгийн Засаг даргын тамгын газар нь төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүрт сул орон тоог зарлах арга хэмжээ аваагүй Нийгмийн бодлогын хэлтсийн даргыг 01 дүгээр сараас, Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн даргыг 8 дугаар сараас, Гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтэнг 6 дугаар сараас, Хууль тогтоомжийн мэдээлэл, системчлэл, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэнг 10 дугаар сараас нөөцөд бүртгэлгүй албан хаагчаар түр орлон гүйцэтгүүлж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараахь тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн

жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно” гэснийг зөрчсөн байна.

Аудитаар илэрсэн 37,412.2 мянган төгрөгийн санхүүгийн асуудлын зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул агдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байхгүй												
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын нөөц хөрөнгөөс тэмдэглэлтэй, баярын арга хэмжээнд зарцуулсан	1	23,552.2			1	22,371.0						
Сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн тэтгэмжийг хууль тогтоомж зөрчиж олгосон	1	13,860.0	1	13,860.0								
Дүн	2	37,412.2	1	13,860.0	1	22,371.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг бүрэн байршуулаагүй	1	1,097,347.3			1	1,097,347.3		
Дүн	1	1,097,347.3	-	-	1	1,097,347.3	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоог зарладаггүй	1	-			1	-		
Дүн	2	1,097,347.3	-	-	2	1,097,347.3	-	-
Нийт дүн	2	1,097,347.3	-	-	2	1,097,347.3		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 70 - А2370448

Чингис хот

ХЭА - 2026/093/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн аймгийн Засаг даргын орлогчоор ажиллаж байсан иргэнд 13,860,000.00 (арван гурван сая найман зуун жаран мянга) төгрөгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөний тэтгэмж олгосон байна.

Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хууль тогтоомж зөрчиж олгосон тэтгэмжийн 13,860,000.00 ((арван гурван сая найман зуун жаран мянга) төгрөгийг тус байгууллагын дарга А.Жаргалсайхан, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нараар төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын дарга А.Жаргалсайханд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 215 - А2370448

Чингис хот

ХЭА - 2026/093/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөр дээш үнийн дүн бүхий зарлагын 40,894,866.00 (дөчин сая найман зуун ерэн дөрвөн мянга найман зуун жаран зургаан) төгрөгийн 5 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,056,452.458.00 (нэг тэрбум тавин зургаан сая дөрвөн зуун тавин хоёр мянга дөрвөн зуун тавин найм) төгрөгийн 70 худалдан авалтыг мэдээлээгүй байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг ил тод мэдээлдэггүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга А.Жаргалсайхан, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН!

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 216 - А2370448

Чингис хот

ХЭА - 2026/093/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүрд сул орон тоог нөхөх арга хэмжээ аваагүй, Нийгмийн бодлогын хэлтсийн даргыг 01 дүгээр сараас, Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн даргыг 8 дугаар сараас, Гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтэнг 6 дугаар сараас, Хууль тогтоомжийн мэдээлэл, системчлэл, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэнг 10 дугаар сараас нөөцөд бүртгэлгүй албан хаагчаар түр орлон гүйцэтгүүлж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно" гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон гарсан тохиолдолд олон нийтэд мэдээлдэггүй, хуульд заасан шаардлага хангаагүй албан хаагчаар гүйцэтгүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга А.Жаргалсайханд даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 217-А2370448

Чингис хот

ХЭА-2026/093/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 23,552,150.00 (хорин гурван сая таван зуун тавин хоёр мянга нэг зуун тавь) төгрөгийг нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээнд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно." гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь.**

1. Төсвийн хөрөнгийг нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээнд зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга А.Жаргалсайханд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА

